



ХЭНТИЙ АЙМГИЙН
УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/25

Хэрлэн сум

Зөвлөгөөн зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.9 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын 2025 оны Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт тусгагдсан албан хаагчдын мэргэшлийн ур чадварыг сайжруулах, ажиллах урам зоригыг нэмэгдүүлэх зорилгоор Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн албан хаагчдын туршлага солилцох уулзалт, зөвлөгөөнийг 2025 оны 03 дугаар сарын 14-16 өдрүүдэд Хэрлэн суманд зохион байгуулсугай.

2. Уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, удирамжийг 2 дугаар хавсралтаар тус тус батласугай.

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд дааслгасугай

Ажлын хэсгийн ахлагч: М.Энхцэцэг
Нарийн бичиг : Г.Бямбасүрэн
Гишүүд: Г.Нямсүрэн
Б.Ганганбайгал
П.Наранцэцэг
Ч.Уранчимэг
Х.Магвансүрэн
С.Баясгалан

ДАРГА

Б.ХЭРЛЭНЧИМЭГ



Хэнтий аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн
даргын 2025 оны 4/25 дугаар тушаалын хавсралт

ЗҮҮН БҮСИЙН УС, ЦАГ УУРЧДЫН МЭРГЭШЛИЙН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН УДИРДАМЖ

Зорилго: “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын бүсчилсэн үзэл баримтлал, Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Ус, цаг уур орчны хяналт шинжилгээний салбарын “Хүн төвт хөгжлийн төлөвлөгөө”-ний 3.3 дахь зорилтын хүрээнд албан хаагчдын мэргэшлийн ур чадвар, чадамжийг дээшлүүлэх, ажиллах урам зоригийг нэмэгдүүлэн тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хүлээгдэж буй үр дүн: Ус, цаг уур орчны хяналт шинжилгээний салбарын үйл ажиллагааны үр дүн жигд нэмэгдэж, албан хаагчдын мэргэшлийн ур чадвар сайжирна.

Зохион байгуулагч: Хэнтий аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төв

Хамтран зохион байгуулагч: Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газар

Оролцогч:

- ✓ Сүхбаатар аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв -25 албан хаагч
- ✓ Дорнод аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв- 25 албан хаагч
- ✓ Хэнтий аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв -30 албан хаагч

Хугацаа: 2025 оны 03 дугаар сарын 14-16 өдрүүдэд Хэнтий аймгийн Чингис хотод

Зохион байгуулагдах арга хэмжээний жагсаалт

- ✓ Уулзалт хэлэлцүүлэг -2025 оны 03 дугаар сарын 14 өдөр – УЦУОШТ-ийн хурлын танхимд
- ✓ Спортын арга хэмжээ -2025 оны 03 дугаар сарын 15 өдөр – Хэрлэн 4 дүгээр сургуулийн биеийн тамирын танхимд

Туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлгийн удирдамж

№	Арга хэмжээ, сэдвийн нэр	Хугацаа	Хариуцах байгууллага албан тушаалтан
1	Уулзалт хэлэлцүүлгийн нээлт	13:00-13:10	Хэнтий аймгийн Аймгийн ЗДТГ-ын БНХОБТХ-ийн дарга Д.Баярхүү Хэнтий аймгийн УЦУОШТ-ийн дарга Б.Хэрлэнчимэг
2	Сүхбаатар аймгийн УЦУОШТ-ийн бидний туршлага, ололт амжилт танилцуулга	13:10-13:40	Сүхбаатар аймгийн УЦУОШТ-ийн дарга Х.Энхбаяр
3	Дорнод аймгийн УЦУОШТ-ийн бидний туршлага, ололт амжилт танилцуулга	13:40-14:10	Дорнод аймгийн УЦУОШТ-ийн дарга Г.Гарамхишиг
4	Хэнтий аймгийн УЦУОШТ-ийн бидний туршлага, ололт амжилт танилцуулга	14:40-14:40	Хэнтий аймгийн УЦУОШТ-ийн дарга Б.Хэрлэнчимэг
5	Асуулт хариулт	14:40-15:10	Оролцогчид
Завсарлага 15:10-15:30			
Салбар хэлэлцүүлгүүд явагдана.			
6	Цаг агаарын урьдчилсан мэдээний таарц, Нисэхийн цаг уурын үйлчилгээ	15:30-16:30	Мэдээлэл, үйлчилгээний хэлтсийн дарга Т.Нарангэрэл /403 тоот өрөөнд/
7	Байгаль орчны шинжилгээний лабораторийн харьцуулсан шинжилгээ		БОШЛ-ын эрхлэгч, чанарын менежер Б.Ганганбайгал /407 тоот өрөөнд/
8	Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны төлөвлөлт, үр дүн		ЦАЗНЭ-ийн үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэбаатар / 301 тоот өрөөнд/
9	Цаг уурын улсын сүлжээ, хөтөлбөрийн ажлын чанар		ХААЦУ-ын технологич инженер Ч.Уранчимэг /405 тоот өрөөнд/
10	Гадаргын ус судлалын хөтөлбөрт ажлын чанар		ЦУОТХ-ийн дарга М.Энхцэцэг /404 тоот өрөөнд/
11	Ус, цаг уур, уур амьсгалын үйлчилгээ		Ус судлалын судалгааны инженер С.Баясгалан /Хурлын танхимд/
12	Багаж хэмжил зүй, систем сүлжээ ашиглалт	16:30-17:00	Систем сүлжээ хариуцсан технологич инженер Ц.Түвшинтөгс /401 тоот өрөөнд/
	Нэгдсэн хэлэлцүүлэг		Оролцогчид

**ЗҮҮН БҮСИЙН УС, ЦАГ УУРЫН САЛБАРЫН АЛБАН ХААГЧДЫН ДУНД
ЗОХИОН БАЙГУУЛАХ СПОРТЫН 5 ТӨРӨЛТ
ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

2025.02.10

1.Зорилго:

Зүүн бүсийн аймгуудын Ус, Цаг уурын салбарын албан хаагчдын уулзалт, харилцан туршлага солилцох, спортоор өрсөлдөх, хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжих

2. Зохион байгуулагч:

Хэнтий аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төв

3. Тэмцээний хуваарь, болох газар:

Тэмцээн 2025 оны 03 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Хэрлэн IV сургуулийн спорт зааланд болно.

4. Хамрах хүрээ:

Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн УЦУОШТ-ийн албан хаагчид

5. Тэмцээний төрөл:

- Сагсан бөмбөг- эрэгтэй 6 , эмэгтэй 6
- Гар бөмбөг- эрэгтэй 8, эмэгтэй 8
- Теннис- эрэгтэй 1, эмэгтэй 1
- Дартс- эрэгтэй 1, эмэгтэй 1
- Шатар- эрэгтэй 1, эмэгтэй 1 тамирчид

6. Тэмцээний хураамж:

Аймаг тус бүр- 1,000,000 төгрөг

7. Тэмцээний шагнал:

- Сагсан бөмбөг, Гар бөмбөг 1-р байр өргөмжлөл, мөнгөн шагнал
- Теннис, Дартс, Шатар 1,2-р байр өргөмжлөл, мөнгөн шагнал
- Шилдэг тоглогч эрэгтэй, эмэгтэй - цом, мөнгөн шагнал
- Багийн нийлбэр оноогоор: 1-р байр шилжин явах цом, мөнгөн шагнал

8. Техникийн зөвлөгөөн:

Техникийн зөвлөгөөн 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 14 цагаас онлайн хэлбэрээр зохион байгуулна.

Техникийн зөвлөгөөнд аймгуудын УЦУОШТ-ийн дарга нар, спорт хариуцсан ажилтан, багийн ахлагч нар оролцоно. Багийн мэдүүлгийг хаягаар 2025 оны 03 сарын 10-ны 13 цагаас өмнө ирүүлнэ үү.

Багийн мэдүүлгийн загвар

Д/д	Овог нэр	Албан тушаал	Хувийн дугаар	Хүйс	Нас	Байрлал	НД төлсөн сар

9. Тоглоомын дүрэм:

- Дартс- Эхний 2 хожлоор явагдана. 501 онооноос хасч 2-ын үржвэрээр тэглэнэ. 45 сум дууссан тохиолдолд бухын нүд шидэж ойрхон оносон нь хожлыг авна.
- Шатар- Тойргийн системээр, 1 талдаа 20 минут байна.
- Сагсан бөмбөг- Эрэгтэй 2 үеэр, 8 минут, эмэгтэй 2 үеэр 6 минут
- Гар бөмбөг- 21 оноогоор 2 хожлоор тоглолт явагдана.

Холбоо барих утас:

Синоптик инженер Г. Бямбасүрэн 88031978

Радарын техникч Х. Магвансүрэн 98116319